

Хүний Эрхийн Үндэсний Комисс
Засгийн газрын 11 дүгээр байр, 5 дугаар давхар
Эрх Чөлөөний талбай, Улаанбаатар 38
Утас: 260987
Факс: 260987
Э-шуудан: p.oyunchimeg@mn-nhrc.org

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“ҮНДЭСНИЙ ЦӨӨНХ ЦААТАН ХҮҮХДҮҮДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН БАЙДАЛ” ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг: Оршил

Үндэсний цөөнхөд хэл соёл, шашин шүтлэг, угсаатны зүй, газар нутаг, зан заншил зэргээсээ шалтгаалан олонхоос ялгарах бүлгийг хамааруулж үздэг бөгөөд тэдний эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бүрдүүлэх нь тухайн үндэстэн төдийгүй дэлхий улс орнуудын анхаарах асуудлын нэг байдаг.

НҮБ-ын үндэсний цөөнхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Francesco Capotorti-ийн тодорхойлолтоор үндэсний цөөнх гэдэгт “...Өөрсдийн соёл, үндэс угсаа, шашин эсвэл хэлний өвөрмөц онцлогоо хадгалан үлдсэнийхээ улмаас улсынхаа хүн амын дунд ил биш амьдардаг, хүн амын багахан хэсгийг бүрдүүлдэг, бусад хүн амтай адил байдлаар нийгмийн амьдралд тэгш дүүрэн оролцож чаддаггүй бүлэг хүмүүсийг хэлнэ.”¹ гэжээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27 дугаар зүйлд “Угсаатан, шашны болон хэлний цөөнх оршин суудаг улсад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тийм бүлгийн бусад гишүүнийхээ хамтаар соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй” хэмээн цөөнхийг эрхийг баталгаажуулсан.

Олон улсын хэмжээнд цөөнхийн эрхийн хамгаалалт нь оршин байх, тусгаарлагдахгүй байх, ялгаварлан гадуурхахдахгүй байх, уусахгүй байх гэсэн шаардлагад үндэслэдэг бөгөөд үүнийг 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Үндэстний, угсаатны, шашны болон хэлний цөөнхөд харьяалагддаг хүмүүсийн эрхийн тухай Тунхаглал”-д тодорхой зааж баталгаажуулсан.

Энэхүү тунхаглал нь цөөнхийн эрхийн асуудлаарх олон улсын эрх зүйд баримтлах гол баримт бичиг бөгөөд түүнийг улс орнууд НҮБ-ын гишүүн болохын хувьд тунхаглалын зүйл заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Монгол Улсын хууль тогтоомжид үндэсний цөөнхийн талаар тусгайлсан тодорхойлолт байхгүй ч зарим зүйл, заалтад үндэсний цөөнхийн асуудлаар тусгасан байна. Тухайлбал, Монгол Улсын Соёлын тухай хууль болон бусад хуульд “үндэстний цөөнх” гэсэн үг, үсэг шууд хэрэглээгүй боловч “үндэстэн ястан” болон “хөдөөгийн хүн амын” гэсэн ерөнхий утгын хүрээнд уг ойлголт томъёологдож тусгалаа олжээ². Монгол Улсын Үндсэн хууль, болон бусад 5 хууль, УИХ-ын тогтоолоор баталсан 3 хөтөлбөр, ЗГ-ын тогтоолоор баталсан 7 хөтөлбөрт тус тус үндэстний цөөнхийн асуудлаар зарим заалтыг оруулсан байх бөгөөд эдгээр нь үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, соёл зан заншлаа өвлүүлэх эрхийг ерөнхий хүрээнд нь баталгаажуулсан заалтууд байна.

¹ Study on the Rights on Persons belonging to Ethnic⁸ Religious⁸ Linguistic Minorities UN Document E/CN.4/Sub.2/384/Add+.1-7 (1977)

² Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр /1995 оны 19 дүгээр тогтоол/, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2004/, Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай /№202,2005.9.28/.

Монгол Улсын үндэстний цөөнхийн бүлэгт Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвөөс 50-70 км алслагдсан, хөвдөн бэлчээртэй, аглаг тайга бүхий өндөр ууланд цаа буга маллаж, амьдардаг уйгар угсааны тува (Духа) хүмүүс багтдаг бөгөөд анх тэднийг 1955 онд 53 өрх, айлын гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын иргэн болгожээ. Эдгээр бүлэг хүмүүсийг ахуйн шинж, цаа буга малладаг онцлогийг нь тодотгон “Цаатан” хэмээн нэрлэж хэвшжээ.

Тухайн үед төр засгийн зүгээс цаатан иргэдийн амьдрал, ахуй нөхцлийг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулан тэднийг тайгын бөглүү амьдралаас ангижруулж, төвд суурьшуулан байшинд амьдруулах зэрэг оролдлогыг хийж, цаа буга маллахын зэрэгцээ загас, ан агнуурын аж ахуйг эрхлүүлэх, хүүхдүүдийн сурч боловсрох орчныг бүрдүүлэх, сургууль, цэцэрлэг байгуулах, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд идэвхтэй дэмжлэг тусалцаа үзүүлэх, ОХУ-ын Автономит Тува улсын их, дээд сургуулиудад суралцуулах, мөн нийгмийн халамжийн дэс дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байжээ. Түүнчлэн, 1985 оны АИХТ-ийн 245 дугаар зарлиг, СнЗ-ийн 26 дугаар тогтоолоор Цагааннуур сумыг шинээр байгуулах шийдвэр гарч 143 өрх, 500 гаруй хүн амтай, 682 цаатай, 2900 толгой малтай, 1,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр бие даасан сум болгон байгуулжээ.

1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үеийн жилүүдэд цаатан иргэд олноор ажиллаж байсан загас агнуурын аж ахуй нь татан буугдан, тэнд ажиллаж байсан цаатан иргэд тайгадаа эргэн ирж, улмаар урьд өмнө төрөөс явуулж байсан нийгмийн халамжийн бодлого, үйлчилгээ байхгүй болсон нь цаатан иргэдийн амьдралд хүндээр тусч, цаа бугаа хүнсэнд хэрэглэх, цусан эврийг борлуулах, ангийн олзоор амьдрах зэрэг өнөө маргаашаа аргацаан амьдрах болсон байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2004 оны Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит илтгэлдээ Үндэсний цөөнхийн эрхийн төлөв байдлын талаар буюу үүндээ цаатан иргэдийн эрхийн асуудлыг хөндөж, УИХ, ЗГ болон олон нийтэд анхаарал хандуулсны үр дүнд Монгол Улсын Засгийн газраас 2007 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 255 дугаар тогтоолоор “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр” Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 387 тоот тушаалаар “Тува хэлний хөтөлбөр”-ийг тус тус батлагдсан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар бүлгийн 2.4.3.5-д “Үндэсний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангаж, тэдний үр хүүхдийн эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулна” гэж заасан байдаг.

Монгол Улс нь төр, засгийн зүгээс үндэстний цөөнх болсон цаатан иргэдийг анхаарал хандуулж тодорхой хэмжээгээр бодлого, эрх зүйн баримт бичигт тусгах, ялангуяа тэдгээрийн амьжиргааны эх үүсвэр болсон цаа бугын тоо толгойг өсгөн нэмэгдүүлэх, цаатан иргэдийн нийгмийн асуудлыг дээшлүүлэхээр цогц хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай.

Хөтөлбөрийг 2015 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд түүнд дэвшүүлсэн Цаатан иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ.

- Албан бус сургалтуудыг зохион байгуулах;
- Аялал жуулчлалын анхан шатны мэдлэг олгох, цааны гаралтай түүхий эдээр бэлэл дурсгалын эд зүйлс хийх ур чадварт сургах;
- Цаанаас өөр төрлийн малын ашиг шим, бүтээгдэхүүнийг боловсруулах сургалтанд хамруулах;
- Экологи, эрүүл мэндийн сургалтанд хамруулах;
- Хүүхдийн сургууль завсардалтаас сэргийлэх;
- Тува хэлний хичээлийг сургалтын төлөвлөгөөн дэх сургуулийн мэдлийн цагийн хүрээнд зохицуулах;
- ОХУ-ын Кызылийн багшийн сургуультай хамтран ажиллах, сурах бичгийг тува хэл дээр орчуулах;
- Үнэ төлбөргүй сурах бичиг, сурагчийн дүрэмт хувцсаар хангах;
- Сурагчдын дотуур байрыг өртгөтгөн тохижуулах;
- Цаатан хүүхдийг их дээд сургуульд элсэн суралцах сургалтын төлбөрийг төрийн сангаас гарган, дотуур байрны төлбөрийг төрөөс хариуцах зэрэг болно.

Хоёр: Үйл ажиллагаа

Хүний эрхийн Үндэсний Комисс нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хэрэгжүүлж буй “Үндэсний цөөнх цаатан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт” төслийн хүрээнд “Соён-тайга” төрийн бус байгууллагатай хамтран 2010 оны 1 дүгээр сарын 6-18-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумд оршин суудаг үндэсний цөөнх цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийн байдалд цогц судалгааг хийв.

Судалгааны зорилго нь Монгол Улсын үндэсний цөөнхийн хамгийн бага төлөөлөл болох цаатан иргэдийн эрх ашгийг хамгаалах, хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангуулах, тэр дундаа цаатан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан тогтоох, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг дэвшүүлэх, судалгааны нэгдсэн дүнг Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгаж УИХ-д илтгэх, УИХ, ЗГ-аас тодорхой арга хэмжээ авахуулах, олон улсын байгууллага, иргэний нийгэм, олон нийтэд хүргэх, танилцуулах, сурталчлахад чиглэгдэж байгаа болно.

Судалгааны баг нь цаатан иргэдийн амьжиргааны өнөөгийн байдлыг тогтоохоор анкетын судалгааг 47 асуулгаар бэлтгэн 50 өрх айлын 70 гаруй цаатан иргэдээс, сургуулийн орчин нөхцөл, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн талаар дунд сургуулийн дунд болон ахлах ангийн 43 сурагчдаас 29 асуулгаар, бага ангийн 70 сурагчдаас 29 асуулгаар бөглүүлэн авч, өрхийн анкетийн асуулга болон сурагчдаас авсан судалгааны дүнг нэгтгэж, ерөнхий нөхцөл байдлыг хувьд шилжүүлэн гаргалаа.

Мөн Цагааннуур сумын Засаг дарга, холбогдох албан тушаалтнууд, иргэдтэй ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, цаатан иргэдийн амьдрал, ахуй нөхцөл, нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдаж байгаа эсэх, цаа бугын тоо толгойг нэмэгдүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээ болон

шашин шүтлэг, төрөлх хэлээрээ ярих, өөрсдийн соёл заншлаа хадгалан үлдэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид төрийн зүгээс анхаарах асуудлаар харилцан ярилцаж, санал хүсэлтийг сонсох, тэмдэглэл хийх, хүүхдийн сургууль, цэцэрлэгийн орчин, сурагчдын дотуур байрны нөхцөл байдалтай танилцан, тэнд амьдарч буй хүүхдүүдтэй биечлэн уулзаж, ярилцлага хийн, тэмдэглэл хөтлөх, стандартад нийцэхгүй байсан объектуудыг фото зургаар бэхжүүлэх, цаатан иргэдийн талаарх анхан шатны бүртгэл судалгаа, аймаг орон нутгийн мэдээ тайлан холбогдох баримт бичгийг цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, харьцуулан судлах, ажиглалт хийх зэрэг аргаар судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Гурав: Үр дүн

Судалгааны баг цаатан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн байдлыг дараах асуудлын хүрээнд хөндөж байна. Үүнд:

Цаатан иргэдийн нэгдсэн тоо бүртгэлийн талаар

2009 онд гаргасан “Цаатан өрх, иргэдийн үндсэн судалгаа”-тай танилцахад нийт цаатан 168 өрх айл байгаагаас баруун тайгад 34 өрхийн 134 хүн, зүүн тайгад 28 өрхийн 98 хүн тус тус амьдардаг бөгөөд хүйсийн хувьд авч үзвэл 112 эрэгтэй, 120 эмэгтэй байгаа гэсэн дүн мэдээтэй байна³.

Цэвэр цаатан өрх айл (духа) 85, холимог⁴ цаатан өрх айл 83 байгаа бөгөөд нийт 675⁵ иргэд байна. Үүнийг задалбал: (Хүснэгт 1)

Цаатан өрх			Нийт хүн			Тайгад амьдарч байгаа		Хүйсээр		Өрхийн дотроос	
Бүх өрх	үүнээс		Бүх хүний тоо	үүнээс		үүнээс		эрэгтэй	эмэгтэй	Өрх толгойлсон эмэгтэй	Өрх толгойлсон эрэгтэй
	цэвэр	холимог		Цаатан	бусад	баруун	зүүн				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
168	85	83	675	426	249	34/134хүн	28/98хүн	112	120	8	6

Судалгааны баг Цагааннуур сумын ЗДТГ-ын албан хаагчидтай хийсэн уулзалтын үеэр тус сумын Засаг дарга Д.Мягмаржав нь “...нийт цаатан 138 өрхийн 664 хүн байгаагаас цэвэр цаатан 436 хүн, холимог 228 хүн байна...”⁶ гэж мэдэгдсэн нь дээрх цаатан өрх, иргэдийн судалгааны тоон мэдээнээс зөрүүтэй байгаа тул үүнийг сум, орон нутгийн зүгээс цаатан иргэдийн талаар нэгдсэн дэлгэрэнгүй судалгаа байхгүй байгаагаар холбон үзэхээс өөр аргагүй юм.

³2009 оны 08 дугаар сарын 17-ны байдлаар Цагааннуур сумын ИТХ-ын дарга Г.Буянтогтохын гаргасан “Цаатан өрх, иргэдийн үндсэн судалгаа”

⁴ Дархад болон бусад үндэстэн, ястантай гэр бүл болсон цаатан иргэд

⁵ Сумын төвд амьдардаг цаатан болон холимог нийт гэр бүл, хүний тоо

⁶ Цагааннуур сумын Засаг дарга Д.Мягмаржаваас авсан мэдээлэл, 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр ЗДТГ-ын албан хаагчидтай хийсэн уулзалтын тэмдэглэлээс

Төрөлх хэлээрээ ярих эрхийн хэрэгжилт

Цаатан иргэд өөрсдийн төрөлх хэл болох тува хэлээ зөвхөн хоорондын харилцааны түвшинд л хэрэглэдэг болжээ. Дунд сургуульд тува хэлийг үзэхгүй байгаа нь төрөлх хэлээ мартаход хүргэж байгаа хэмээн үзэж байна.

Цагааннуур сумын 9 жилийн дунд сургуульд нийтдээ цаатан 135 хүүхэд суралцаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 387 тоот тушаалаар батлагдсан “Тува хэлний хөтөлбөр” нь өнөөдрийг хүртэл тус сумын сургуульд хэрэгжээгүй байгаа ба зөвхөн сонгон суралцах хичээл хэлбэрээр сургуульд заадаг байна.

50 өрхийн 70 гаруй хүн оролцуулан хийсэн анкетийн судалгааны асуулгад Тува хэлээр хоорондоо ярьдаг уу гэсэн асуултанд 84 хувь нь тийм, 16 хувь нь үгүй, Монгол хэлээр ярихад хүндрэл учирдаг уу гэсэн асуултанд 90 хувь нь үгүй, Ямар хэлээр ярихыг илүү гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд Тува хэл гэж 28 хувь, Монгол хэл гэж 40 хувь үзэж байгаа бол үлдсэн 26 хувь аль аль хэлээр гэж тус тус хариулсан байна.

Монгол хэлээр ярихыг илүү гэж үзэж байгаа шалтгаан нь Монгол Улсын иргэний хувьд монгол хэл нь дээр, бусадтай ойлголцоход хялбар бөгөөд тува хэл мөхөж монголжиж байгаа учир монгол хэл нь дээр болж гэж тайлбарыг хийж байсан хэдий ч дийлэнх хэсэг нь тува хэлээр ярьдаг хүмүүс бага болж, бидний үр хүүхдүүд тува хэлийг огт хэрэглэхгүй, ойр зуурын, гэр бүл, ахуйн хүрээнд настангууд голдуу хэрэглэж байгаад сэтгэл эмзэглэх болсон тухай тэмдэглэсэн байна.

Харин тува хэлээр хоорондоо харьцдаг хүмүүсийн тухайд төрөлх хэл маань мартагдах талдаа байгаа учраас сэргээн санаж ярьдаг, төрөлх хэлээрээ ярихад сайхан байдаг, хоорондоо харьцахдаа хурдан ойлгодог, хөгширсөн учраас ярихад хялбар байдаг гэсэн хариултыг хийсэн байна.

Үүнээс үзэхэд цаатан иргэд нь тува хэлээ авч үлдэх хэрэгтэй гэдэг үүднээс тува хэлээр ярилцахыг илүү гэж үзэж байгаа хэдий ч тэрээр зөвхөн ойр зуур, гэр бүл, ахуйн хүрээнд хэрэглэх төдий болжээ.


Сурч боловсрох эрхийн хэрэгжилт

Цаатан иргэдийн боловсролын түвшинг авч үзэхэд нилээд доогуур үзүүлэлттэй байна. Түүнчлэн, цаатан иргэдээс тусгай дунд боловсролтой хүн хамгийн өндөр боловсролтойд тооцогдож, харин бага, дунд боловсролтой иргэд дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа ч тэдний дунд бичиг үсэг тайлагдаагүй цөөнгүй иргэд байна. Дээд боловсролтой гэх хэдэн цаатан иргэд нь Цагааннуур сумын төвд амьдарч байна.

Зөвхөн баруун, зүүн тайгад амьдардаг 212 иргэний боловсролын байдлыг судалбал (Хүснэгт 2):


Боловсролгүй	Бага	ББДунд	Бүрэн дунд	Тусгай дунд	0-6 насны
29	65	56	28	4	48

Хувьчилбал: 232 хүнээс



2008 оны 8 дугаар сарын 17-ны байдлаар, ИТХ-ын дарга Г. Буянтогтохын гаргасан судалгаагаар


320 хүүхэд сургах хүчин чадалтай Цагааннуур сумын 9 жилийн дунд сургуулийг анх 1990 онд ашиглалтанд оруулж байжээ. 1999 онд сургуулийн барилга шатсаны тул 2000 онд “Цаа буга” сангийн санаачлага, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 1 давхар сургуулийн байшинг шинээр барьжээ. Одоогоор тус сургуулийн 17 бүлэгт 403 хүүхэд суралцаж, анги дүүргэлт 24,5 хувьтай, үүнээс 135 нь цаатан хүүхэд сурч байгаа бөгөөд нийт сурагчдын 33 хувийг эзэлж байна.



Эдгээр цаатан хүүхдийн 45 нь баруун, зүүн тайгаас ирж суралцаж байгаа бол үлдсэн 90 нь сумын төв болон тал нутагт мал маллан амьдарч байгаа цаатан гаралтай иргэдийн хүүхэд байна. Баруун, зүүн тайгад 0-6 насны 48 хүүхэд амьдарч байна⁷. Нэг ангид дунджаар 8-15 цаатан хүүхэд суралцаж байна.

⁷ Цагааннуурын 9 жилийн сургуулийн нийгмийн ажилтан Г.Батцэцэгийн гаргасан судалгаанаас

Баруун, зуун тайгын 45 хүүхдүүдийг:



Цаатан иргэдийн хүүхдүүдийн сургуульд элсэлт сүүлийн 3 жилээр (Хүснэгт 3);

Элсэлтийн он	2006-2007 он	2007-2008 он	2008-2009 он
Нийт хүүхэд	269	275	279
Тоо	20	22	22
Хувь	7.4	8	7.88

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 9 дүгээр анги төгсөлт сүүлийн 3 жилээр (Хүснэгт 4);

Төгссөн он	2006-2007 он	2007-2008 он	2008-2009 он
Нийт хүүхэд	20	22	22
Тоо	7	12	17
Хувь	35	54.5	77.3

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 10 дугаар ангид элсэлтийн байдал сүүлийн 3 жилээр (Хүснэгт 5);

Дэвшин суралцсан он	2006-2007 он	2007-2008 он	2008-2009 он
Хүүхдийн тоо	7	12	17
Тоо	4	8	8
Хувь	57.1	66.7	47

(Сургуулийн захирал Ц.Дариймаагийн гаргасан судалгаанаас)

Сургууль завсардалтын мэдээг судлахад 2006-2007 оны хичээлийн жилд 3 хүүхэд, 2007-2008 оны хичээлийн жилд 3 хүүхэд, 2008-2009 оны хичээлийн жилд 2 хүүхэд нийт I-Ү ангийн 10-13 насны 8 хүүхэд завсардсан байна.

Сургууль завсардалтын гол шалтгаан цаатан хүүхдүүд 9 дүгээр ангиа төгсөөд зэргэлдээх сумдын сургуульд очиж сурах болдог бөгөөд ар гэр тогтмол орлогогүйгээс тэдний зардлыг гаргахад хүндрэлтэй, ах дүү, хамаатан садангийн айл байхгүйгээс сургуульд явуулдаггүй гэж цаатан иргэдтэй хийсэн ярилцлагын үеэр хэлж байв.

Цаатан хүүхдийн оюуны чадвар, сурах арга барил, стандарт эзэмшилт-сурлагын чанар бусад хүүхэд, үе тэнгийнхэнтэйгээ адил байдаг. Гэвч сургуульд ортлоо тайгад амьдарч байгаад ирсэн хүүхдүүдийн хувьд хэл ярианы хөгжил муутай, монгол хэлээр ойлгох, илэрхийлэх чадвар сул байдаг нь тэдний сурах идэвх, сонирхол, сурлагын үзүүлэлтэд багагүй нөлөөлдөг. Цаатан хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжгүй, сургуульд ортлоо тува, монгол хэлээр хольж ярьдаг орчинд амьдардаг. Тэд дээрх хоёр хэлний аль алианаар нь ойр зуурын хэрэглээний түвшний мэдлэгтэй сургуульд орж ирдэг байна.

Багшлах боловсон хүчин, сургалтын орчин нөхцөл

Сурч боловсрох эрхийг хангах баталгаа нь багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж, сургалтын орчин нөхцөл юм. Тус сумын дунд сургуульд нийт 31 багш ажилладаг бөгөөд 1-36 жил боловсролын байгууллагад багшилж байгаа бакалавр, магистрийн зэрэгтэй багштай. Цагааннуур сумын дунд сургуульд 2002 онд цаатан гаралтай 5 бага ангийн багш ажиллаж байсан бол одоо сургуулийн 2 багш, 1 ажилтан тува хэлтэй байна.

Тухайлбал, Б.Саранчимэг “Чингис хаан” дээд сургуулийн гадаад харилцааны ангийг төгссөн англи хэлний багш мэргэжилтэй, С.Навчаа Тувагийн Кызылийн багшийн коллежийг бага ангийн багш мэргэжлээр төгссөн тува хэлтэй, С.Батаа сургалтын менежерээр ажилладаг, тува хэлтэй. Энэ гурван хүнээс өөр тува хэлтэй, тува хэлний хичээлийг заах боловсон хүчин байхгүй. Тува хэлний хичээлийг 7 хоногт 7 цагаар сонгон суралцах хэлбэрээр зөвхөн 7-9 дүгээр ангийн хүүхдүүдэд ордог бөгөөд зөвхөн ярианы дадлага олгох хэмжээнд заадаг байна.

Сурагчдаас багш нарын хичээл заах арга барил туршлагын талаар асуулга явуулахад ахлах дунд ангийн 70 сурагчдаас манай багш нар хичээлээ маш сайн заадаг гэж 51 сурагч буюу 72.8 хувь нь, сайн гэж 19 хүүхэд буюу 27.2 хувь нь хариулсан хүүхдүүдийн 4.6 хувь нь агуулгын хувьд ойлгомжгүй, мэдэхгүй гэсэн бол монгол хэлээр бага зэрэг ойлгодог гэсэн хариултыг 27 хүүхэд буюу 62.8 хувь, ойлгомжтой гэсэн хариултыг 13 хүүхэд буюу 30.2 хувь, хариулаагүй 1 хүүхэд байна. Ер нь дөнгөж сургуулийн босго алхан орж байгаа тува хүүхдүүд эцэг эхтэйгээ өөрийн хэлээр ярьж дадсан, монгол хэлний үгсийн сан муутай, задалж ойлгох чадвар сул байдагтай холбоотой байна.

Сурах нөхцөлийг сургууль бүрэн хангаж байгаа эсэх талаар тайгын 113 хүүхдээс⁸ санал асуулга авахад дунд ахлах, ангийн 50 хүүхэд буюу 71.4 хувь нь тийм гэсэн хариултыг өгсөн бол 19 хүүхэд буюу 27.1 хувь нь үгүй гэсэн хариултыг өгчээ. Үгүй гэсэн хариултыг задлан судлахад өвлийн цагт хэт хүйтэн, намар хэт халуун, ангиудын самбар, сурагчийн ширээ хэт хуучирсан, эвдэрхий, номын сангийн номнууд хуучирсан, шинэ сүүлийн үеийн мэдээ, ном сонин ховор байдаг гэжээ.

⁸ Ханиадны карантини дараа авсан судалгаа тул зарим хүүхдүүд тайгаас сургуульдаа ирээгүй байсан болно.

Сургуулийн хүчин чадал, тоног төхөөрөмж, ном, сурах бичгийн судалгааг задлан харуулбал⁹ (Хүснэгт 6):

Номын сан	Номын тоо	Хөдөөгийн боловсролыг дэмжих "READ" сангаас өгсөн ном	ширээ	сандаг	самбар
1	4100	1280	240	400	16

2009 онд тус сум цахилгаанаар хангагдсантай холбоотойгоор сургуулийн техник хэрэгслэлийн тоо нэмэгдэж компьютер, принтер, каноныг ашиглаж сурах бололцоо нээгдэж байгаа нь сайшаалтай. Сургуулийн хэмжээнд нийт 14 компьютер, 5 принтер, 1 канон ашиглагдаж байгаа хэдий ч хүүхдүүд тэр болгон ашиглан, сурах дадлага хийж чаддаггүй гэж хариулжээ.

Сургуулийн дотуур байрны тухайд

Сургуулийн дотуур байр нь 1987 онд захиргааны зориулалтаар баригдсан байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд нийт 17 өрөөтэй, өрөөний хэмжээ 2,5х 4,5 м², ойролцоогоор 6-8 хүүхэд нэг өрөөнд байрладаг, нийт 75 хүүхдийн багтаамжтай байна.

2010 оны байдлаар дотуур байранд 151 хүүхэд байрлуулсан нь бараг хэмжээнээсээ 2 дахин их хүүхэдтэй байна. Дотуур байранд амьдардаг 151 хүүхдээс 63 цаатан хүүхэд амьдардаг бөгөөд үүнээс 39 хүүхэд баруун, зүүн тайгаас, үлдсэн 24 хүүхэд нь сумын төвийн ойролцоо Хармай, Хогорго, Цагаан ус, Давааны өвөр зэрэг газруудад намаржиж, өвөлжиж нутаглаж байгаа цаатан иргэдийн хүүхдүүд байна.

Дотуур байрны хүрэлцээ хангамжийн талаар судлахад (Хүснэгт 7):

Хүрэлцээ	Хүүхдийн тоо	Орны тоо	Хөнжил/ гудас	Даавуу	Бүтээлэг	Ширээ	Сандаг	Угаалтуур
75	151	107	98/104	160 хос	7	18	48	18

(Дотуур байрын багш М.Мөнхтуяагийн гаргасан судалгаанаас 2010.01.11)

Судалгааны баг нь дотуур байрны нөхцөл байдалтай танилцаж, тэнд амьдарч байгаа хүүхдүүдтэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийхэд дараах асуудлууд анхаарал татаж байлаа.

Сургуулийн дотуур байрны хана тааз суусан, цууралттай, жин их цохисон, гэрэлтүүлэг хангалтгүй, өрөөний багтаамж хангалтгүйгээс гол төлөв нэг өрөөнд 8-12 давхар ор байршуулсан байна. Дотуур байрны ор, хөнжил, гудас хангамж, хүрэлцээ хангалттай бус, хөнжил, гудас нимгэн, өрөө хүйтэн, шөнө галлагаагүй хонодог учраас хүүхдүүд гэрээсээ хөнжил, гудас авчруулдаг, садангийн болон төрсөн ах, эгч дүүсээрээ өвөртөө хамт унтдаг байна.

⁹Цагааннуур сумын дунд сургуулийн сургалтын менежер С.Батаагийн гаргасан судалгаа.2010.01.12

Дотуур байрны хүүхдүүд орой үдшийн цагт өөрсдөө түлээ модоо зөөж, өрөөндөө гал түлдэг, хувцас угаах усаа өөрсдөө голоос зөөдөг, заримдаа хэт хүйтэнд голоос ус зөөхөд хацар чихээ хайрах явдал гардаг, өрөөнүүд голдуу 1 ширээ 2 сандалтай, өрөөний багтаамж бага, олон хүүхэд хүүхдүүд хичээлээ ээлж ээлжээр 1 цагийн зайтай давтдаг, ширээ, сандалын хүрэлцээгүйгээс түлээний тайрдас модыг сандал болгон ашигладаг, орон дээрээ авдараа тавьж хичээлээ давтдаг, ном, сурах бичгийн хүрэлцээ мөн хангалтгүй тул дундаа ном сурах бичгээ дамжуулж хэрэглэдэг байна.

Түүнчлэн, хичээлийн хоцродол ихтэй, хичээл давтах цаг бага, голдуу хувцас угаах, гал түлэх, ус зөөх, дүү нараа асрах зэрэг ахуйн ажил ихтэй байдгаас хичээлээ давтах, номын санд суух цаг бага байдаггүй, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөл бүрдээгүй, номын сангийн баяжилт хангалтгүй, ном, сурах бичиг хомс, биеийн тамирын заал өвлийн улиралд ажиллахгүй, хаалттай байдаг тухай өгүүлж байлаа.

Дөрөв: Дүгнэлт

Цаатан иргэдийн амьдран суудаг аймаг, орон нутаг нь төвөөс хэт алслагдсан дэд бүтэц сайн хөгжөөгүй, томоохон үйлдвэр аж ахуйн байгууллага байхгүй, ажилгүйдэл, ядуурал өндөртэй, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, эрхээ эдлэхэд таагүй нөлөө үзүүлж байна.

Үндэстний цөөнхийн эх хэлээрээ ярих, мэдээлэл авах, сурч боловсрох, зан заншил, уламжлалаа хадгалан үлдээх, соёлын өвөө хадгалах зэрэг эрхүүдийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газраас тодорхой нэгдсэн арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй байна.

Үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого хангалтгүй байна. Тухайлан цаатан иргэдийн эрхийг талаар гаргасан Засгийн газрын хөтөлбөр болон яам агентлагуудаас батлан гаргаж хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, баримт бичгүүдэд ямар ч хяналт байдаггүй, тэдний зарим нь зөвхөн цаасан дээр байгааг анхаарах нь зүйтэй.

Цаатан хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, ном сурах бичгийг даруй хэвлэн гаргах, орчуулах, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн сайжруулах ажлыг даруй эхлэх хэрэгтэй. Хэрэгжиж буй хөтөлбөр бусад ажлууд дээр хөндлөнгийн хяналтын байгууллагыг газар дээр нь ажиллуулан, бодит үнэлгээг гарган үр дүнг танилцуулдаг байдлыг хэвшүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Цагааннуур сумын сургуулийн дотуур байрыг шинээр стандартад нийцүүлэн барих, дотуур байрны хүүхдүүдийн ахуй нөхцлийг сайжруулах, сурч боловсрох орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай болсон байна.

Тав. Санал, зөвлөмж

Цаатан иргэдийн нийгмийн асуудлыг нэн даруй шийдвэрлэхэд чиглэгдсэн бодлогын арга хэмжээг сум орон нутгийн удирдлагуудтай хамтран боловсруулан хэрэгжүүлэх;

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын санал санаачлагыг бодитойгоор дэмжин ажиллах;

2005 онд батлагдсан Тува хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэн тува хэл дээр ном сурах бичгээр сумын дунд сургуулийн хүүхдүүдийг хангах;

Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих хөндлөнгийн хяналтын механизмыг цаатан иргэдийн оролцоотойгоор бий болгон ажиллуулах;

Цагааннуур сумын хүүхдийн дотуур байрыг шинээр барьж байгуулах, дотуур байранд мөрдөгдөх стандарт дүрмийг шинэчлэн тогтоох;

Ядуурлыг бууруулах төсөл хөтөлбөрүүдэд цаатан ажилгүй иргэдийг хамруулан ажлын байраар хангах, улирлын чанартай ажил гүйцэтгэх боломжийг судлан гаргаж хэрэгжүүлэх;